

## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ИРГЭН ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ТАВИХ ШААРДЛАГА, БҮРТГЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Барилгын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1<sup>1</sup>-д заасан чиглэлээр улс, орон нутгийн төсөв болон хандивлагч олон улс, банк санхүүгийн байгууллагын хөрөнгө оруулалтаар баригдах барилга байгууламжийн барилгын үйл ажиллагааны<sup>2</sup> барилгын салбарын мэргэжлийн зөвлөх үйлчилгээ<sup>3</sup> үзүүлэх иргэн, хуулийн этгээдэд тавих шаардлагыг тогтоож, тэдгээрийг бүртгэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэхүү журмыг мөрдлөгө болгоно.

1.3. Хуулиар төрийн нууцад хамааруулсан, эсхүл үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгай зориулалтын барилга байгууламжийн үйл ажиллагаанд зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээд энэхүү журамд заасан шаардлагыг хангасан байх бөгөөд тэдгээрийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна.

1.4. Барилгын салбарын мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээд нь энэхүү журам болон Иргэний хууль, Барилгын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг удирдлага болгоно.

1.5. Зөвлөх үйлчилгээ үзүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг энэхүү журам болон зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ (цаашид "гэрээ" гэх)-гээр нарийвчлан зохицуулна. Гэрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын даалгавар, хөтөлбөр, график, үйлчилгээний хөлс болон гэрээний хугацаа, талуудын эрх, үүрэг, хариуцлага, гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгох нөхцөл, хөрөнгө оруулагч (захиалагч), зөвлөхийн харилцан тохиролцсон бусад асуудлыг тусгана.

1.6. Энэхүү журмын 1.1-д зааснаас бусад хөрөнгийн эх үүсвэрээр зөвлөх үйлчилгээ авах тохиолдолд шаардлагатай гэж үзвэл энэхүү журмыг жишиг болгон мөрдөж болно.

1.7. Барилгын салбарын мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэхдээ дараах үндсэн зарчмыг баримтална. Үүнд:

- 1.7.1. хууль тогтоомж, техник технологи, менежментийн хөгжилтэй уялдуулан мэдлэг, ур чадвараа хадгалах;
- 1.7.2. хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлж, мэргэжлийн зөвлөгөө өгөх, шийдвэр гаргахад шудрага, аливаа ашиг сонирхлоос ангид байх;
- 1.7.3. тодорхой ажилд өөр зөвлөхийн ажлыг дүгнэх тохиолдолд ёс зүйг баримтлан, ашиг сонирхлоос ангид, ажилд нь шууд болон шууд бусаар оролцож саад учруулахгүй байх;

<sup>1</sup> 42.1. Барилгын салбарын мэргэжлийн зөвлөх үйлчилгээг дараахь чиглэлээр үзүүлнэ:

<sup>2</sup> 4.1.20. "барилгын үйл ажиллагаа" гэж барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг боловсруулах, магадлал хийх, барилгын ажил гүйцэтгэх, үе шатны ажилд хяналт тавих, чанар аюулгүй байдлын шинжилгээ хийх, ашиглалтад оруулж, гэрчилгээжүүлэхийг;

<sup>3</sup> 4.1.29. "зөвлөх үйлчилгээ" гэж барилгын үе шатны ажил гүйцэтгэх, норм, нормативын баримт бичиг боловсруулах, барилгын материалын үйлдвэрлэлийн технологийн сонголт, механик-автоматжуулалт, тохируулга, зүгшрүүлэх, чанар аюулгүй байдлын түвшин, төлөв байдлыг тогтооход шаардлагатай мэргэжил, тусгай мэдлэг, ур чадварын үндсэн дээр үзүүлж байгаа мэргэжлийн үйлчилгээг;

- 1.7.4. бусдын нэр хүнд, бизнест санаатай болон санамсаргүйгээр, хайхрамжгүй хандах, хохирол учруулахаар үйлчилгээ үзүүлэхгүй байх;
- 1.7.5. нийгмийн хариуцлагатай, тогтвортой хөгжилд нийцсэн байх;
- 1.7.6. бусдын нөлөөнд үл автах, хөрөнгө оруулагч (захиалагч)-ийн хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, нууцыг чанд хадгалах.

### **Хоёр. Барилгын салбарын мэргэжлийн зөвлөх үйлчилгээний чиглэл**

2.1. Барилгын салбарын мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээд Барилгын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.1<sup>4</sup>-ээс 42.1.8-д заасан чиглэл, түүнд хамаарах ажлын хүрээгээр бүртгүүлнэ.

2.2. Энэхүү журмын 2.1-д заасан чиглэл тус бүрт хамаарах ажлын хүрээг 1 дүгээр хавсралтад заасан ба шинэ техник, технологи, инноваци, цаг үеийн зэрэг шаардлагаар нэмэлт ажлын хүрээгээр бүртгүүлэх асуудал нь нээлттэй байна.

### **Гурав. Барилгын салбарын мэргэжлийн зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт**

3.1. Барилгын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2-т заасны дагуу Барилгын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4<sup>5</sup>, 10.1.5<sup>6</sup>-т заасан ангиллын барилга байгууламжийн үйл ажиллагаанд энэхүү журамд заасны дагуу бүртгүүлсэн зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдээс сонгон гүйцэтгүүлнэ.

3.2. Хөрөнгө оруулагч, захиалагч Барилгын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1<sup>7</sup>, 10.1.2<sup>8</sup>, 10.1.3<sup>9</sup>-т заасан ангиллын барилга байгууламжийн үйл ажиллагаанд зөвлөх үйлчилгээ авах тохиолдолд энэхүү журамд заасны дагуу бүртгүүлсэн зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдээс сонгоно.

---

<sup>4</sup> 42.1.1.инженер-хайгуулын судалгаа;

42.1.2.хөрөнгө оруулалтын судалгаа;

42.1.3.барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, норм, нормативын баримт бичиг боловсруулалтын түвшинг тогтоох;

42.1.4.барилгын материалын үйлдвэрлэлийн техник, эдийн засгийн үндэслэл, түүхий эд болон үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний чанар, технологийн хяналт, зөвлөгөө, дүгнэлт гаргах, тоног төхөөрөмжийн угсралт, лабораторийн болон үйлдвэрлэлийн туршилт хийх, технологийн горим тогтоох;

42.1.5.барилгын ажлын механикжуулалт, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, оношилгоо, засвар, техникийн үйлчилгээ, тохируулга, зүгшрүүлэлт хийх ажлын технологи, аргачлал тогтоох;

42.1.6.барилгын ажлын үе шатанд хяналт тавих, барилга байгууламжийн ашиглалтын үеийн чанар, аюулгүй байдлын төлөвт дүгнэлт гаргах;

42.1.7.төслийн удирдлага, зохион байгуулалт, технологийн түвшин;

42.1.8.барилга байгууламжийн захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх;

<sup>5</sup> 10.1.4.өндөр төвөгшилтэй барилга байгууламж;

<sup>6</sup> 10.1.5.онцгой төвөгшилтэй барилга байгууламж;

<sup>7</sup> 10.1.1.барилгын ажлын зөвшөөрөл шаардахгүй барилга байгууламж;

<sup>8</sup> 10.1.2.бага төвөгшилтэй барилга байгууламж;

<sup>9</sup> 10.1.3.дунд зэргийн төвөгшилтэй барилга байгууламж;

## Дөрөв. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдэд тавих шаардлага

4.1. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн дараахь шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- 4.1.1. тухайн чиглэл бүрт хамаарах ажлын хүрээгээр /1 дүгээр хавсралт/ зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах зохих мэргэжил, чадвар эзэмшсэн, тухайн ажлын хүрээгээр Барилгын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3.2, 44.3.3-д заасан мэргэшлийн зэрэгтэй;
- 4.1.2. тухайн чиглэл, ажлын хүрээгээр 3-аас (1 бүтээл нь судалгаа, дүн шинжилгээ хийсэн байх) доошгүй бүтээлтэй;
- 4.1.3. Барилгын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-д заасан мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулсан байх;

4.2. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 4.2.1. татвар, нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлсэн байх;
- 4.2.2. энэ журмын 2 дугаар хавсралтад заасан орон тооны мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэй байх;
- 4.2.3. хуулийн этгээдийн мэргэжилтнүүдийн аль нэг нь багийн ахлагч байх ба энэ журмын 2 дугаар хавсралтад заасан шаардлагыг багийн ахлагч, мэргэжилтнүүд хангасан байх;
- 4.2.4. зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиглэл, ажлын хүрээнд хамаарах программ хангамж, багаж тоног төхөөрөмж, техник хэрэгсэлтэй байх;
- 4.2.5. тухайн чиглэл, ажлын хүрээгээр 5-аас (1 бүтээл нь судалгаа, дүн шинжилгээ хийсэн байх) доошгүй бүтээлтэй;
- 4.2.6. Барилгын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-д заасан мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулсан байх;

## Тав. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн бүртгэл

5.1. Барилгын салбарын мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэл хөтлөх түүнтэй холбоотой зохион байгуулалтыг Барилгын тухай хуулийн 34 дүгээр зүйл<sup>10</sup>ийн 34.1.11<sup>11</sup>-д заасан байгууллага хариуцана.

5.2. Барилгын салбарын мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэлд бүртгэх үйл ажиллагаа нь цахим систем байна.

5.3. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэнийг дор дурдсан баримт бичиг, мэдээлэлд үндэслэн бүртгэнэ. Үүнд:

5.3.1. зөвлөхийн бүртгэлд бүртгүүлэх хүсэлт;

<sup>10</sup> 34.1. Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

<sup>11</sup> 34.1.11. зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэл хөтлөх;

- 5.3.2. энэ журмын 2 дугаар хавсралтад заасан иргэний мэдээлэл;
  - 5.3.3. зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэний нийгмийн даатгалын лавлагаа, Барилгын тухай хуулийн 8.3-т заасны дагуу мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулсан баримт;
  - 5.3.4. зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэний мэдээлэлд холбогдох баримт бичгийг болон боловсруулсан, эсхүл гүйцэтгэсэн ажлыг тодорхойлсон эрх бүхий байгууллагын баталгаажуулсан тодорхойлолт.
- 5.4. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргасан хуулийн этгээдийг дор дурдсан баримт бичгийг үндэслэн бүртгэнэ. Үүнд:
- 5.4.1. зөвлөхийн бүртгэлд бүртгүүлэх хүсэлт;
  - 5.4.2. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажуулсан хуулбар;
  - 5.4.3. татвар, нийгмийн даатгалын байгууллагад бүртгэлтэй талаарх лавлагаа.
  - 5.4.4. энэ журмын 2 дугаар хавсралтад заасан хуулийн этгээдийн мэдээлэл;
  - 5.4.5. энэ журмын 2 дугаар хавсралтад заасан мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүний талаарх мэдээлэл, мэргэжилтнүүдийн нийгмийн даатгалын лавлагаа, Барилгын тухай хуулийн 8.3-т заасны дагуу мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулсан баримт болон боловсруулсан, эсхүл гүйцэтгэсэн ажлыг тодорхойлсон эрх бүхий байгууллагын баталгаажуулсан тодорхойлолт баримт бичгийг хавсаргах.
- 5.5. Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авч дор заасны дагуу бүртгэнэ:
- 5.5.1. энэ журамд заасан баримт бичгийн бүрдэл хангагдсан эсэхийг хянах;
  - 5.5.2. зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн мэргэжилтний холбогдох мэдээллийг барилгын салбарын ажилтны нэгдсэн бүртгэлтэй тулгаж хянах;
  - 5.5.3. гаргасан хүсэлт нь энэ журамд заасан шаардлагыг хангасан тохиолдолд нэгдсэн бүртгэлд бүртгэх;
  - 5.5.4. зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийг бүртгэсэн талаарх мэдээллийг цахим хэлбэрээр нийтэд мэдээлэх.
- 5.6. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийг бүртгэх үйл ажиллагааг ажлын 7 хоногт багтаан явуулах бөгөөд бүртгэсэн, эсхүл татгалзсан тухай хариуг хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.
- 5.7. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийг 5 жилийн хугацаагаар бүртгэх бөгөөд мөн хугацаагаар тус тус сунгана.
- 5.8. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг дараах тохиолдолд бүртгэлээс хасч болно. Үүнд:
- 5.8.1. иргэн, хуулийн этгээд өөрөө хүсэлт гаргасан;

- 5.8.2. зөвлөх үйлчилгээ үзүүлэх бүртгэлийн хугацаа дууссан бөгөөд түүнийг сунгуулах тухай хүсэлт гаргаагүй;
- 5.8.3. хуурамч баримт бичиг бүрдүүлж, бүртгүүлсэн нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон;
- 5.8.4. Барилгын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон;
- 5.8.5. хуулийн этгээд татан буугдсан, дампуурсан;
- 5.8.6. орон тооны мэргэжилтнүүд ажлаас чөлөөлөгдсөн;

### **Зургаа. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн мэдээллийн сан**

6.1. Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн бүртгэл, мэдээллийн санд байх бөгөөд мэдээллийн сан дараах мэдээллийг агуулна. Үүнд:

- 6.1.1. зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн нэр, регистрын дугаар;
- 6.1.2. бүртгэгдсэн огноо;
- 6.1.3. зөвлөх үйлчилгээний чиглэл, ажлын хүрээ, ижил төстэй ажлын жагсаалт;
- 6.1.4. зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн хувьд багийн ахлагч болон мэргэжилтнүүдийн мэдээлэл, гадаад хэлний мэдлэг, зэрэг дэв, ажлын туршлага, ажилласан жил;
- 6.1.5. зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ үзүүлж байсан талаарх мэдээлэл;
- 6.1.6. зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, албан ёсны эрхтэй програм хангамжийн талаарх мэдээлэл;
- 6.1.7. Барилгын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-д заасан мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулсан талаарх мэдээлэл.

6.2. Мэдээллийн сан нь захиалагч, хөрөнгө оруулагч мэдээллийн сангаас шүүлт хийж өөрийн гүйцэтгүүлэх ажилд зохих зөвлөхийг сонгож болохуйц нээлттэй дата бааз, платформ байна.

6.3. **Мэдээллийн сан нь салбарын болон бусад холбогдох мэдээллийн сантай холбогдож мэдээлэл солилцох боломжтой байна.**

### **Долоо. Бусад**

7.1. Барилгын салбарын төрийн захиргааны байгууллага зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэлтэй холбогдон гарсан санал, гомдлыг хуульд заасны дагуу шийдвэрлэж, нэгдсэн бүртгэлийн талаар нийтэд мэдээлэх, эрх бүхий байгууллагад тайлагнах, мэдээлэх ажлыг зохион байгуулан хэрэгжүүлнэ.

7.2. Энэхүү журмыг зөрчсөн мэргэжилтэн албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдэд тавих шаардлага, бүртгэх журмын 1 дүгээр хавсралт

**Зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиглэл, түүнд хамаарах ажлын хүрээ**

1. Инженер-хайгуулын судалгааны чиглэлд хамаарах ажлын хүрээ:
  - 1.1. барилга барих талбайн инженер-геологийн ажлын даалгавар бэлдэх, зөвшилцөх;
  - 1.2. инженер-геодези, инженер-геологи, геотехник, гидрогеологи, газар хөдлөлт, байгаль, ус, цаг уурын нөхцөлийг тогтоосон судалгаа хийх, түвшин тогтоох, зөвлөмж гаргах;
  - 1.3. шаардлагатай бол /инженер-геодези, инженер-геологи, геотехник, гидрогеологи, газар хөдлөлт, байгаль, ус, цаг уурын нөхцөлийг тогтоосон судалгаа хийх, түвшин тогтоох, зөвлөмж гаргах/ гэсэн ажлын хүрээгээр барилгын үе шатны ажилд үзлэг хийх, зөвлөмж, дүгнэлт гаргах;
  - ~~1.4. инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний төлөв байдал, түүгээр хангах боломжийг судлах, тогтоох;~~
  - 1.5. сургалт явуулах;
  - 1.6. бусад.
  
2. Хөрөнгө оруулалтын судалгааны чиглэлд хамаарах ажлын хүрээ:
  - 2.1. хөрөнгө оруулалтын судалгаа, шинжилгээ хийх;
  - 2.2. төслийг хэрэгжүүлэх боломж, үндэслэлийг тогтоох;
  - 2.3. төслийн техник-эдийн засгийн үндэслэл, төсвийн төслийг боловсруулах;
  - 2.4. инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний төлөв байдал, түүгээр хангах боломжийг судлах, тогтоох;
  - 2.5. төслийн даалгавар боловсруулах;
  - 2.6. төсөл хэрэгжүүлэх байгууллагын талаар санал боловсруулах;
  - 2.7. сургалт явуулах;
  - 2.8. бусад.
  
3. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, норм, нормативын баримт бичгийн боловсруулалтын түвшин тогтоох чиглэлд хамаарах ажлын хүрээ:
  - 3.1. Барилгын тухай хуулийн 5.1-д заасан норм, нормативын баримт бичгийн техникийн даалгавар болон боловсруулалтын түвшин тогтоох;
  - 3.2. Барилгын тухай хуулийн 4.1.26, 4.1.27, 4.1.43-т заасан болон барилга байгууламжийн техникийн болон ажлын зураг төслийн түвшин тогтоох;
  - 3.3. эдийн засгийн үндэслэл, архитектур төлөвлөлт, техникийн болон ажлын зураг төслийн даалгаврын түвшин тогтоох;
  - 3.4. барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төслийн түвшин тогтоох;
  - 3.5. барилга байгууламжийн архитектур төлөвлөлт, инженерийн тооцоо, техникийн шийдлийн түвшин тогтоох;
  - 3.6. барилгын ажлын тоо хэмжээ, төсөвт өртгийн түвшин тогтоох;

- 3.7. норм, нормативын баримт бичиг, зураг төсөл боловсруулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, тендерийн баримт бичгийн түвшин тогтоох;
- 3.8. технологи, инженерийн шийдлийн хувилбаруудыг судалж, өртөг, хугацаа хэмнэх оновчтой шийдлийг боловсруулах;
- 3.9. барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг боловсруулах;
- 3.10. сургалт явуулах;
- 3.11. бусад.

4. Барилгын материалын үйлдвэрлэлийн техник, эдийн засгийн үндэслэл, түүхий эд болон үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний чанар, технологийн хяналт, зөвлөгөө, дүгнэлт гаргах, тоног төхөөрөмжийн угсралт, лабораторийн болон үйлдвэрлэлийн туршилт хийх, технологийн горим тогтоох чиглэлд хамаарах ажлын хүрээ:

- 4.1. барилгын материалын үйлдвэрийн технологийн тохируулга, зүгшрүүлэлт хийх;
- 4.2. тоног төхөөрөмжийн ашиглалт, төлөвлөгөөт засвар, техникийн үйлчилгээний систем, технологийн зааврыг мөрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;
- 4.3. тухайн барилгын ажилд шаардагдах материалын зах зээлийн эрэлт хэрэгцээ, үйлдвэрлэлийн технологийн дэвшил, аюулгүй ажиллагаа, хийц бүтээц, эдлэхүүний нэр төрөл, чанар, стандарт, ашиглалтын үеийн аюулгүй байдлын баталгаажуулалт хийх, эрдэс түүхий эд, материалын ашиглалт, боловсруулах технологи, бүтээгдэхүүн, түүхий эд, материалын орцын нормыг тодорхойлох;
- 4.4. үйлдвэрлэлийн технологийн заавар, бүтээгдэхүүний стандарт, бүтээгдэхүүнийг барилгад хэрэглэх аргачилсан заавар, үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах, барилгын материалын үйлдвэрийн тоног төхөөрөмж угсрах, туршилт, тохируулга хийх зааварчилгаа боловсруулах, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн турших, сонгох;
- 4.5. сургалт явуулах;
- 4.6. бусад.

5. Барилгын ажлын механикжуулалт, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, оношилгоо, засвар, техникийн үйлчилгээ, тохируулга, зүгшрүүлэлт хийх ажлын технологи, аргачлал тогтоох чиглэлд хамаарах ажлын хүрээ:

- 5.1. машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны норм, нормативын баримт бичгийн төсөл боловсруулах;
- 5.2. машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалт, түүний эд ангийн үйлдвэрлэлийн техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах;
- 5.3. инженерийн зураг төсөл боловсруулах, төслийн ажлын тоо хэмжээг тодорхойлох, өртгийн тооцоо хийлгэх;



- 5.4. машин механизм, тоног төхөөрөмжийн угсралт, ашиглалт, засвар, техникийн үйлчилгээ, оношилгоо, тохируулга, зүгшрүүлэлтийн ажлыг гүйцэтгүүлэх, техникийн хяналт тавих;
- 5.5. сургалт явуулах;
- 5.6. бусад.

6. Барилгын ажлын үе шатанд хяналт тавих, барилга байгууламжийн ашиглалтын үеийн чанар, аюулгүй байдлын төлөвт дүгнэлт гаргах чиглэлд хамаарах ажлын хүрээ:

- 6.1. барилгын ажил гүйцэтгэхэд тавигдах техникийн шаардлага боловсруулах;
- 6.2. барилгын үе шатны ажлын чанар, технологид үнэлэлт дүгнэлт өгөх, тухайн барилга байгууламж батлагдсан зураг төсөл, техникийн шаардлага, технологийн картын дагуу баригдаж байгаа эсэхэд хянаж тавьж, үнэлэлт дүгнэлт өгөх;
- 6.3. барилга байгууламжийг ашиглалтад оруулахад тавигдах техникийн шаардлага боловсруулах;
- 6.4. технологийн тоног төхөөрөмжийн суурилуулалт, тохиргоо, зүгшрүүлэлтийн ажиллагаа үйлдвэрлэгчийн заавар болон барилга байгууламжийн норматив баримт бичгийн шаардлагын дагуу хийгдэж байгаа эсэхэд хяналт тавих;
- 6.5. барилгын байгууламжийн ашиглалтын үеийн чанар, аюулгүй байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- 6.6. ашиглагдаж байгаа барилга байгууламжийн бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гаргах, паспортжуулах;
- 6.7. барилгын ажлын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа болон эрүүл ахуйн шаардлага хангагдаж байгаад хяналт тавих;
- 6.8. сургалт явуулах;
- 6.9. бусад.

7. Төслийн удирдлага, зохион байгуулалт, технологийн түвшингийн чиглэлд хамаарах ажлын хүрээ:

- 7.1. төслийн баримт бичгийн боловсруулалт, түүний хэрэгжилтийг үе шат бүрээр хянаж, баталгаажуулах, үйл ажиллагааны горим дарааллыг тодорхойлох, мөрдүүлэх;
- 7.2. зураг төслийн болон барилгын төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил, гүйцэтгэлийн чанар технологийн хяналтыг хэрэгжүүлэх;
- 7.3. төслийн багийн бүтэц, зохион байгуулалт, ажлын чиг үүргийг тодорхойлсон удирдамжийг боловсруулж, хэрэгжүүлэх явцад зөвлөгөө өгөх;
- 7.4. төслийн ажил, үйлдвэрлэлийн зохион байгуулалт, технологийн процессын үйл ажиллагааны биелэлтийг хянах;
- 7.5. техник технологийн сонголт, шийдлийн талаар санал боловсруулах;

- 7.6. төслийн техникийн шаардлагын баримт бичгийг нэгтгэн боловсруулах, ажлын цар хүрээ, ажлын багц, түүний задаргааг нарийвчлан гаргах;
  - 7.7. ажилбаруудын горим дарааллыг тодорхойлох, тэдгээрийн ханган нийлүүлэлт, гүйцэтгэлийн хугацааг тооцоолон нэгдсэн хөтөлбөр гаргах, барилгын ажлын үе шат бүрийн зорилтот огноог тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих;
  - 7.8. урьдчилсан төсөв, мөнгөн урсгалын төлөвлөгөө гаргах, хэрэгжилтэд хяналт тавих;
  - 7.9. чанарын удирдлага, чанарын хяналт болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын төлөвлөгөөг гаргах, хэрэгжилтэд хяналт тавих;
  - 7.10. төслийн харилцаа холбооны төлөвлөгөө гаргах, төслийн мэдээлэл тайлан, баримт бичгийг цаг хугацаанд нь боловсруулах, бүрдүүлэх, хүргүүлэх, дамжуулах болон хадгалах үйл ажиллагааг зохион байгуулах;
  - 7.11. эрсдэлийг тодорхойлох, чанарын эрсдэл, үнийн эрсдэл, хугацааны нөлөөллийн эрсдэлийн үнэлгээ хийх, тэдгээрийг бууруулах эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө гаргах, хэрэгжилтэд хяналт тавих;
  - 7.12. төслийн удирдлагын нэгдсэн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх;
  - 7.13. сонгон шалгаруулалтын багцыг нэгтгэн боловсруулах, сонгон шалгаруулалтын төлөвлөгөө боловсруулах, зураг төсөл зохиогч, барилгын ажлын гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч нарыг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах, сонгон шалгаруулалтын үнэлгээний тайлан, зөвлөмж боловсруулахад зөвлөгөө өгөх, тайлан зөвлөмж гаргах;
  - 7.14. барилгын ажлын талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төслийн хэрэгжилтэд хяналт тавих;
  - 7.15. барилгын ажлын гүйцэтгэгчийн боловсруулсан аргачлал, технологийн карт, горимын схемийг шалгаж баталгаажуулах;
  - 7.16. төслийн хэрэгжилтийн явцад гарсан өөрчлөлтүүдийг хянах, түүнтэй холбоотой гарах өртөг, хугацааны нөлөөллийг үнэлэх, зохицуулалт хийх;
  - 7.17. төслийг эхлүүлэх, хаах, барилга байгууламжийг ашиглалтад оруулах, хүлээлгэж өгөх ажлыг удирдан зохион байгуулах, үе шатны болон хаалтын тайлан гаргах, өгөөжийг дүгнэх;
  - 7.18. Барилгын тухай хуулийн 4.1.4-т заасан барилга байгууламжийн баримт бичгийн боловсруулалт, түүний хэрэгжилтийг үе шат бүрээр хянаж баталгаажуулах.
  - 7.19. сургалт явуулах;
  - 7.20. бусад.
8. Барилгын тухай хуулийн 37.1-д заасны дагуу захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэл.

Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдэд тавих шаардлага, бүртгэх журмын 2 дугаар хавсралт

**ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД БАЙВАЛ ЗОХИХ ХҮНИЙ НӨӨЦ**

Зөвлөх үйлчилгээний чиглэл	Зөвлөх үйлчилгээний чиглэлд хамаарах ажлын хүрээ	Шаардлагатай мэргэжилтэн	Багийн ахлагч	Мэргэжилтнүүд
1	2	3		
1	1.1 1.2 1.3 1.4 1.5	-Инженер-геологийн инженер -Гидро-геологи инженер -Хот төлөвлөлтийн архитектор -Геодезийн инженер -Дулаан хангамж эсхүл халаалт, агаар сэлгэлтийн инженер -Ус хангамж, ариутгах татуургын инженер -Цахилгаан эсхүл автоматикийн инженер -Холбоо, дохиолол, мэдээллийн сүлжээний инженер	-Хэрэгжиж буй төслийн зонхилох ажлын чиглэлээр 15-аас доошгүй жил ажилласан  -Зөвлөх инженер буюу тухайн чиглэлийн мэргэжлээр эрдмийн цол, зэрэгтэй	-Хэрэгжиж буй төслийн зонхилох ажлын чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан
2	2.1 2.2 2.3 2.4 2.5 2.6 2.7	-Барилга хөрөнгө оруулалтын төслийн менежментийн мэргэжилтэн -Тухайн салбар, үйл ажиллагааны чиглэлийн эдийн засагч -Тухайн салбар, үйл ажиллагааны чиглэлийн инженер -Үнэлгээ, төсөв, тооцоо, хөрөнгө оруулалтын мэргэжилтэн	-Тухайн чиглэлийн мэргэжлээр 3-аас багагүй норм боловсруулахад оролцсон	-Мэргэшсэн буюу зөвлөх инженер байх бөгөөд тухайн чиглэлийн мэргэжлээр магистр болон түүнээс дээш цолтой
3	3.1 3.2 3.3 3.4 3.5 3.6 3.7 3.8 3.9	-Архитектор -Барилгын инженер -Үйлдвэрлэлийн технологич -Механик инженер -Дулаан хангамж эсхүл халаалт, агаар сэлгэлтийн инженер -Ус хангамж, ариутгах татуургын инженер -Цахилгаан эсхүл автоматикийн инженер -Холбоо, дохиолол, мэдээллийн сүлжээний инженер -Инженер-геологийн инженер -Геодезийн инженер -Барилгын эдийн засагч-төсөвчин	-Тухайн чиглэлээр 5-аас доошгүй бүтээл гаргаж, зохиогчоор ажилласан.	-Тухайн чиглэлийн мэргэжлээр  1-ээс цөөнгүй норм боловсруулахад оролцсон

4	4.1 4.2 4.3 4.4	-Барилгын материалын үйлдвэрийн технологич инженер -Барилгын материалын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн механик инженер -Цахилгаан эсхүл автоматикийн инженер -Дулаан хангамж эсхүл халаалт, агаар сэлгэлтийн инженер -Ус хангамж, ариутгах татуургын инженер	Эсхүл мөн тэр хэмжээний барилга угсралтын ажил гүйцэтгэсэн.	-Тухайн чиглэлээр 3-аас доошгүй бүтээл гаргаж, зохиогчоор ажилласан. Эсхүл мөн тэр хэмжээний барилга угсралтын ажил гүйцэтгэсэн.  -Гадаад хэлний мэдлэг
5	5.1 5.2 5.3 5.4 5.5	-Механик инженер -Цахилгаан эсхүл автоматикийн инженер	-Гадаад хэлний мэдлэг	
6	6.1 6.2 6.3 6.4 6.5 6.6	-Архитектор -Барилгын инженер -Механик инженер -Дулаан хангамж эсхүл халаалт, агаар сэлгэлтийн инженер -Ус хангамж, ариутгах татуургын инженер -Цахилгаан эсхүл автоматикийн инженер -Холбоо, дохиолол, мэдээллийн сүлжээний инженер -Геодезийн инженер -Барилгын эдийн засагч-төсөвчин -Барилгын инженер -Барилгын материалын технологи инженер -Барилгын салбарын инженер (Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх сургалтад хамрагдаж, сертификат авсан байна.) -Галын инженер		
7	7.1 7.2 7.3 7.4 7.5 7.6 7.7 7.8 7.9 7.10 7.11 7.12 7.13 7.14 7.15	-Архитектор -Барилгын инженер -Тухайн салбар, үйл ажиллагааны чиглэлийн эдийн засагч -Тухайн төслийн чиглэлийн технологич инженер -Барилгын эдийн засагч-төсөвчин		

	7.16 7.17			
8	-	<ul style="list-style-type: none"> <li>-Архитектор</li> <li>-Барилгын инженер</li> <li>-Инженер-геологийн инженер</li> <li>-Геодезийн инженер</li> <li>-Дулаан хангамж эсхүл халаалт, агаар сэлгэлтийн инженер</li> <li>-Цахилгаан эсхүл автоматикийн инженер</li> <li>-Ус хангамж, ариутгах татуургын инженер</li> <li>-Холбоо, дохиолол, мэдээллийн сүлжээний инженер</li> <li>-Барилгын эдийн засагч-төсөвчин</li> <li>-Барилгын материалын үйлдвэрийн технологич инженер</li> <li>-Барилгын салбарын инженер (Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх сургалтад хамрагдаж, сертификат авсан байна.)</li> </ul>		